

## Нэг. 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

**Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт**

Багануур ХК нь Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний Дулааны цахилгаан станцууд болон бусад хэрэглэгчийн захиалгат нүүрсийг тасралтгүй нийлүүлэн ажиллаж байна. Хөрс хуулалтын төлөвлөгөөг 2023 оны 9 сарын байдлаар 13048.5мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 3265.1мян.тн нүүрс олборлоод байна.

Уулын ажлууд	Оны эхнээс 9 сараар		
	төл	гүйц	%
НИЙТ ХӨРС ХУУЛАЛТ /мян.м <sup>3</sup> /	12780.0	13048.5	102%
ТЭЭВЭРГҮЙ ХӨРС /мян.м <sup>3</sup> /	1140.0	1621.7	142%
АВТО ХӨРС /мян.м <sup>3</sup> /	11500.0	11214.4	98%
Хайрга /мян.м <sup>3</sup> /	100.0	160.6	161%
Шимт хөрс /мян.м <sup>3</sup> /	40.0	51.8	130%
ШИДЭЛТ /мян.м <sup>3</sup> /	2220.0	2431.2	110%
ИНЖЕНЕРИЙН АЖИЛ /мян.м <sup>3</sup> /	395.0	433.0	110%
Авто и/ажил /мян.м <sup>3</sup> /	50.0	189.7	379%
Ангилан ялгалт /мян.тн/	45.0		0%
НҮҮРС ОЛБОРЛОЛТ /мян.тн/	3246.9	3265.1	101%
НҮҮРС БОРЛУУЛАЛТ /мян.тн/	3246.9	3258.2	100%
УУЛЫН ЦУЛААР /мян.м <sup>3</sup> /	20474.8	21120.3	103%

**Хоёр. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

**1. Агаарын чанар**

1.1. 2023 онд Уул-1 хэсэгт 11500м, Уул-2 хэсэгт 16000м, нийт 27500м замыг хайргажуулж түрж тэгшилсэн.

**2023 онд хийгдсэн замын ажлын мэдээ**

Д/д	Уулын-1 хэсэг						
	Улирал	Нэгдүгээр улирал	Хоёрдугаар улирал			Гуравдугаар улирал	
	Зам,	Хайрга-жуулсан зам,	Хайрга-жуулсан зам,	Тусгаарлах зурвас,	Хамгаалах далан,	Хайрга-жуулсан зам,	Хамгаалах далан,
1	№2250	1 км	0.5 км	0.5 км	1 км	1 км	0
2	№323						
3	№33						
4	№50	0.5 км	1 км	0.5 км	1 км	1 км	0
5	№35	1 км	1 км	0.5 км	0.5 км	1 км	0.5 км
6	№1426						
7	№2111	0.5 км	0.5 км	0.3 км	0.5 км	1 км	0
8	Төв зам	0	1 км	0.5 км	0	0.5 км	0
9	<b>Нийт</b>	<b>3 км</b>	<b>4 км</b>	<b>2.3 км</b>	<b>3 км</b>	<b>4.5 км</b>	<b>0.5 км</b>

д/д	Уулын-2 хэсэг						
	Улирал	Нэгдүгээр улирал	Хоёрдугаар улирал			Гуравдугаар улирал	
	Зам	Хайрга-жуулсан зам	Хайрга-жуулсан зам	Тусгаарлах зурвас	Хамгаалах далан	Хайрга-жуулсан зам	Тусгаарлах зурвас
1	№492	0.5 км	1 км	0.5 км	1 км	2 км	0.5 км
2	№476						
3	№1941	1 км	1 км	0.5 км	0.5 км	1 км	0
4	№1592						
5	№2090						
6	№1581	0.5 км	1 км	0	0	1 км	0.5 км
7	№2074						
8	№1946	1 км	1 км	1 км	1 км	1.5 км	0.5 км
9	№61	1 км	0.5 км	2 км	0	0	0
10	Төв зам	0	1 км	1 км	0.5 км	1 км	1 км
11	<b>Нийт</b>	<b>4 км</b>	<b>5.5 км</b>	<b>3 км</b>	<b>5 км</b>	<b>6.5 км</b>	<b>2.5 км</b>

1.2. Замын тоос дарах зам усалгааны ажлыг 4-р сараас эхлэн 30тн-ын HOWO №150, №170, №171 гэсэн усны 3 машин ажиллалаа. 2023 онд нийт 22825км замыг 136950тн усаар усалсан байна.

Үзүүлэлтүүд	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	Нийт
Усалсан замын урт	2550	3090	3780	2970	3360	3460	3615	22825
Усалсан усны хэмжээ	15300	18540	22680	17820	20160	20760	21690	136950

Үзүүлэлтүүд	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Усалсан замын урт /км/	69178	56499	57850	61303	22825
Усалсан усны хэмжээ /тн/	145750	143560	142460	148590	136950

- ❖ Уурхайн дотоод тээврийн замын тоосыг дарах усалгааг 30тн-ын HOWO №150, №170, №171 гэсэн усны 3 машин машинуудаар тогтмол хийж байна.



- 1.3. Технологийн автомашины хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хурднаас хамаарсан осол эрсдэлд оруулахгүй байх үүднээс хурдыг хязгаарлах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг. Технологийн авто машинуудын дээд хурдыг 35 км/цагаас хэтрүүлэхгүй байхаар GPS-хяналтын системээр тогтмол хянаж байна.

Тээврийн хэрэгслүүдийн хурд хэтрүүлж болзошгүй замын шулуун хэсгүүд болон уулзвар бүхий газруудад хурд сааруулагчийг тавьсан бөгөөд 7 хоногт 3 удаа ээлжит бус үзлэг шалгалтаар хяналт тавьж ажиллаж байна.

- 1.4. Уулын тоног төхөөрөмжүүдийн их засварын 22 ажил төлөвлөсөнөөс 10-р сарын байдлаар графикийн дагуу бүрэн хийгдээд дууссан. Үүнд: ТҮ-2 8 ажил, ТҮ-3 14 засварын ажил хийгдсэн.

Технологийн авто машины засварын 21 ажил төлөвлөсөнөөс агергат засвар 7, хөдөлгүүр солих засварлах 14 ажил, явах анги солих 3 ажил төлөвлөсөн. Үүнээс 14 ажил бүрэн хийгдэж, хугацаа болоогүй 3 ажил, хийгдэж байгаа 3 ажил, дутуу хийгдсэн 1 ажил байна. Технологийн автомашины засварын хэсэг нь төлөвлөгөөт бус урсгал засварын ажлыг цаг тухайд нь гүйцэтгэж байна. Өдөр бүр захиалгийн дагуу өдөрт дунджаар 22 техникийн засварын ажлыг гүйцэтгэж байна.

- 1.5. 2023 оны зуны дизель түлш худалдан авах сонгон шалгаруулалтанд компаниуд орж ирээгүй тул “Шунхлай трейдинг” ХХК, “Содон Ойл” ХХК, “Багануур НИК” ХХК-ийн салбаруудаас, бензинийг “Сод Монгол” ХХК-аас гэрээ байгуулан авч ажиллаж байна. Өвлийн түлшний худалдан авалтын тендер зарласан одоогоор компани орж ирээгүй тул дахин зарлагдаад байна.

- 1.6. Өрөмдлөгө тэсэлгээний ажил явуулах журам болон тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд нийцсэн тэсэлгээний ажлын паспорт боловсруулж, түүнийг мөрдөн өдрийн цагаар гүйцэтгэж ажилласан.

## 2. Гадаргын ба газрын доорхи усны нөөц

Багануур ХК нь 2023 онд 3.6 сая.м<sup>3</sup> усыг шавхан зайлуулж, гол нуур тэжээх болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

- 2.1. 2023 онд 1-9-р сарыг хүртэл Хуцаа голын гольдролыг 309.8 мян.м<sup>3</sup> шүүрүүлэлтийн усаар нөхөн сэргээсэн.
- 2.2. Багагүн нуураас эх авч байсан Хужиртын голын гольдролыг 653.7 мян.м<sup>3</sup> шүүрүүлэлтийн усаар нөхөн сэргээлээ.

Сарууд	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	Нийт
Хужирт голын гольдролд цутгасан усны хэмжээ /м <sup>3</sup>	80430	79138	80437	75002	70403	60553	43532	84378	79792	653665
Хуцаа голын гольдролд цутгасан усны хэмжээ /м <sup>3</sup>	36460	35323	31168	25961	37869	37280	33198	33781	38758	309798

2.3. Дулааны улиралд уурхайн дотоод шүүрлийн усыг шүүрүүлж Уул-1 хэсэгт байгуулсан цөөрөмд цутгаж ажилласан.

2.4. Багагүн нуурыг нийт 35.6 мян.м<sup>3</sup> усаар тэжээсэн.

Сарууд	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	Нийт м <sup>3</sup>
Багагүн нуурыг тэжээсэн усны хэмжээ м <sup>3</sup>	4108	6473	4069	7053	7142	6780	35625

2.5. Багагүн нуурын хөлдөлтийн гүнийг 12-р сард тодорхойлно.

## 3. Хөрсөн бүрхэвч

- 3.1. 2023 оны 9-р сарын байдлаар Уул-1 хэсэгт 21.2 мян.м<sup>3</sup>, Уул-2 хэсэгт 56.9 мян.м<sup>3</sup> нийт 78.1 мян.м<sup>3</sup> шимт хөрсийг хуулж, 51.8 мян.м<sup>3</sup> хөрсийг ачиж агуулахад буулгасан.





- 3.2. Хуулсан шимт хөрсийг агуулахад байршуулж хадгалахдаа "MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт стандартыг мөрдлөг болгон ажиллалаа.


Шинээр үүсгэж байгаа шимт хөрсний агуулахыг 5м-ээс ихгүйгээр өндөртэйгээр байгуулан ажиллаж байна. Уул-1 хэсэгт үүсгэж байгаа шимт хөрсний овоолгийн өндөр стандарт 5м-ээс илүү гарсан тул намсган стандартад оруулахаар үүрэг өгөөд байна.

Уул-2 хэсгийн 7-р сард хуулсан шимт хөрсийг мод үржүүлгийн газарт шууд буулгаж ашигласан. Уул-1 хэсгийн шимт хөрс хуулалтыг 8-10-р сард хийсэн тул ургамалжуулалтыг 2023 онд хийнэ.

- 3.3. Цэгүүдэд байрлуулсан бохир хөрс цуглуулах савны ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, бохир хөрсийг хөрс саармагжуулах талбайд 3 удаа цуглуулан саармагжуулсан.



- 3.4. 2 дахь түүхий эдийн талбайн эхний суллагдсан хэсэг талбайг цэвэрлэсэн. 10-11-р сард үлдэгдэл тос маслыг өгөөд дахин цэвэрлэнэ.



#### 4. Газрын гадарга ба хэвлий

- 4.1. Уулын ажлын олборлолтын үед суулт, гулсалтанд хяналт тавьж эрсдэлтэй үед техник тоног төхөөрөмжийг зайлуулах арга хэмжээ авч ажиллаж байна. 2023 оны байдлаар уулын чулуулгийн шинж чанар, механик үйлчлэлээс шалтгаалан нийт 6 төрлийн хагарал Уул-2 хэсэгт үүссэн. Геотехникийн ажлын хүрээнд хэлтэс, хэсгүүдтай хамтран ажиллаж, аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг хүргүүлэн ажиллаж байна.
- 4.2. Нүүрс гаргалтын ЭКГ-5А №1426 экскаваторын нүүрс тээврийн ТЕХ №1 хүртэлх 5.7 км замын талын зайг 3.6 км-ээр багасган ойртуулан ажилласан.

#### 5. Ургамалан нөмрөг

Багануурын уурхайн ургамалжилтын төлөв байдлын судалгаагаар уурхайн орчимд нийт 28 овгийн 70 төрлийн 90 зүйл ургамал тэмдэглэгдлээ. Үүнд: Үетэн, нийлмэл цэцэгтэн, буурцагтан, холтсон цэцэгтэн, сарнайн овгууд голлох байр эзэлж байна.

#### Ургамлын амьдралын хэлбэр эзлэх хувь




Багануур ХК-ийн ашиглалтын талбай орчмын ургамлуудаас 28 овгийн 70 төрлийн 90 зүйл бэлчээрийн (96.7 %), 22 овгийн 38 төрлийн 45 зүйл эмийн ашигт ургамал (50.0 %), чимэглэлийн 8 овгийн 8 төрөл 8 зүйл (8.9 %), 5 овгийн 5 төрлийн 6 зүйл балт ургамал (6.7 %), 3 овгийн 3 төрлийн 4 зүйл ургамал хүнсний (4.4 %) зориулалтаар ашиглах ач холбогдолтой. Мөн нөхөн сэргээлтэд ашиглах боломжтой 3 овог, 5 төрөл, 5 зүйл 5.6 хувь байгааг тэмдэглэх нь зүйтэй. Нийт 90 зүйлээс 2 зүйл хортой ургамал *Astragalus galactites*. Pall – Шүдэн цагаан, *Stellera chamaejasme* L.- Одой далан түрүү тэмдэглэгдлээ.

**Багануур ХК-ийн ашиглалтын талбайд бүртгэсэн ургамлын зүйлийн бүрдлийн онцлог**

Ач холбогдол ба хор холбогдол	Ангилал зүйн нэгж			Эзлэх хувь
	овог	төрөл	зүйл	
Бэлчээр тэжээлийн ургамал	25	67	87	96.7
Эмийн ашигт ургамал	22	38	45	50.0
Чимэглэлийн	8	8	8	8.9
Балт ургамал	5	5	6	6.7
Хүнсний ач холбогдолтой	3	3	4	4.4
Нөхөн сэргээлтэд ашиглах	3	5	5	5.6
Хортой	2	2	2	2.2
Хөл газрын ургамал	2	3	11	12.2

Бэлчээрийн ургамлаас малд онц сайн идэмжтэй Мөлхөө хиэг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Агь (*Artemisia frigida* Willd.), Нугын биелэг өвс (*Poa pratensis* L.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Ширэг улагж (*Carex duriuscula* C.A.Meу.) зэрэг ургамлууд байна.

Ургамлын зүйлийн бүрдлийн онцлог



Хот, суурин газар орчмын ургамалжилтын ургацыг 1 м<sup>2</sup> талбайд тооцож га-д шилжүүлж гаргахад маш их талхлагдсан бөгөөд бүлгэмдлийн зуны дээд биологийн ургац 5.4-5.9 ц/га, уурхайн ашиглалтын талбайн ашиглагдаагүй талбайн ургац 14.5 ц/га, нөхөн сэргээлт хийсэн талбайд 12.5-14.5 ц/га-гийн ургацтай байна.

**6. Амьтны аймаг**

Амьтны мониторинг судалгаагаар 6 зүйлийн хөхтөн амьтан, 78 зүйлийн шувуудыг бүртгэж тоо толгой, амьдрах орчны болон оршин амьдрах экологийн статус, Дэлхийн байгаль хамгаалах холбооны шалгуур үнэлгээгээр тус тус үнэллээ. Хөхтөн амьтны хувьд “Устаж болзошгүй” цагаан зээр, монгол тарвага төслийн талбайд тархсан бол “Ховордож болзошгүй” хярс үнэг бүртгэгдээд байна.

Цагаан зээрийн хувьд 2 янзагатай нийт 7 бодгаль уурхайн хашаанд, зүүн урд хэсгээр идээшиж байсан бол монгол тарваганы хоёр ичээнд 8-10 орчим бодгаль байх боломжтой. Бид 5 бодгалийг биеэр ажиглаж, хэд хэдэн зусаал нүх, хоёр тусдаа ичээ нүх байгааг баталгаажуулж газрын зурагт буулгах замаар тархац нутгийн хэмжээг үнэлэхэд ойролцоогоор 8 га, хуучин дош (20 орчим), сэргээн нутагшуулах боломжтой талбайг тооцоолоход 600 гаруй гам талбай байлаа.





**Төслийн талбайн хөхтөн амьтны бүртгэл**

№	Зүйлийн нэр	ОУ-ын үнэлгээ	Бүс нутгийн үнэлгээ	Тоо толгой, тархалт
1	Цагаан зээр- <i>Procapra gutturosa</i>	АӨ	УБ	Уурхайн хашаанд 2 янзагатай нийт 7 зээрийг судалгаа хийсэн 2 өдрийн турш давтан бүртгэсэн.
2	Монгол тарвага- <i>Marmota sibirica</i>	УБ	УБ	Уурхайн далангийн зүүн талд, засмал замаас баруун талд 2 ичээнд 10 орчим тарвага бий. Бид хээрийн судалгаагаар давхардаагүй тоогоор 5 бодгаль бүртгэсэн
3	Хярс үнэг- <i>Vulpes corsac</i>	АӨ	ХБ	Уурхайн зүүн талд хашааны дотор 1 бодгаль бүртгэсэн
4	Үлийн цагаан оготно- <i>Lasiopodomys brandtii</i>	АӨ	АӨ	Уурхайн зүүн хэсгээр зөөлөн хөрс бүхий хэсгүүдэд үлий үүсгэн тархсан
5	Монгол чичүүл- <i>Meriones unguiculatus</i>	АӨ	АӨ	Уурхайн зүүн хэсгээр зөөлөн хөрс бүхий хэсгүүдэд, уурхайн үйл ажиллагаанаас үүссэн далан дагаж тархсан.
6	Сибирь алаг даага- <i>Allactaga sibirica</i>	АӨ	АӨ	Уурхайн хашааны дотор болон гадна хэсгээр уурхайлалд өртөөгүй хэсгүүдэд тархсан

АӨ-Анхааралд өртөхөөргүй, ХБ-Ховордож болзошгүй, УБ-Устаж болзошгүй.



**Цагаан зээрийн сүрэг**



**Монгол чичүүл**





**Монгол тарвага**



**Алаг даага**

Үлийн цагаан оготно болон монгол чичүүл мөн уурхайн зүүн талаар буй далангийн зөөлөн хөрс бүхий хэсгүүдэд жигд тархсан бөгөөд тоо толгой нь өсөх хандлагатай байна.

Сибирь алаг даага хашааны дотор байрлуулсан амьд барагчинд баригдсан бол хярс үнэгийг тарваганы хуучин дош орчимд 1 бодгалийг бүртгэсэн болно.


Шувуудын хувьд 12 багийн 28 овогт хамаарах 78 зүйлийг бүртгэсэн бөгөөд нүүдлийн болон дамжин өнгөрдөг зүйлүүд эзэлж байна.

Үүний дотор Олон улсын болоод бүс нутгийн улаан дансны шалгуур үнэлгээгээр “Ховордож болзошгүй, устаж болзошгүй, эмзэг” статусаар үнэлэгдсэн хошуу галуу, нөмрөг тас, улаан хүзүүт шумбуур, тарважи бүргэд зэрэг зүйлүүд байна.

Галууны багийн шувууд нь Аяга нуурт хамгийн олон зүйл, олон тоотойгоор бүртгэгдсэн бол бор шувууны багийн жижиг шувууд уурхай орчмын ногоон байгууламж орчимд, хэрээний болон тагтааны овгийн шувууд уурхайн барилга байгууламж, дүүргийн суурьшлын бүсэд элбэг таарч байлаа.

Хамгийн олон тоогоор халзан түнжүүр Аяга нуур, их гүн болон бага гүн нуурт 1500 орчим, хондон ангир мөн 500 гаруй тохиолдож байлаа. Аяга нуур нь зүйлийн болоод бодгалийн хувьд бусад нууруудаас хамгийн баялаг байсан бөгөөд энд 10 гаруй зүйлийн 1500 орчим нугас нэг доор байлаа.

- Уурхайн эдэлбэр талбайн ойр орчимд бш махчин шувууны суултуур хийж байрлуулсан.



**Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт
1	1	2	
1	Агаарын чанар	Уурхайн дотоод тээврийн замуудыг эвдрэл гарсан тухай бүр сэргээн засч тэгшлэх, шаардлагатай замуудыг хайргажуулах, ус зайлуулах далан суваг хийх	2023 онд Уул-1 хэсэгт 11500м, Уул-2 хэсэгт 16000м, нийт 27500м замыг хайргажуулж түрж тэгшилсэн.
		Уурхайн дотоод тээврийн замын тоосыг дарах усалгааг тогтмол хийх хяналт тавих	Замын тоос дарах зам усалгааны ажлыг 4-р сараас эхлэн 30тн-ын HOWO №150, №170, №171 гэсэн усны 3 машин ажиллалаа. 2023 онд нийт 22825км замыг 136950тн усаар усалсан байна
		Машин техникийн хурдны хязгаарт хяналт тавих	Технологийн авто машинуудын дээд хурдыг 35 км/цагаас хэтрүүлэхгүй байхаар GPS-хяналтын системээр тогтмол хянахаас гадна 7 хоногт 3 удаа ээлжит бус үзлэг шалгалтаар хяналт тавьж ажиллаж байна.
		Хүнд машин механизмуудын болон бусад тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээг тухай бүр тогтмол хийх	Уулын тоног төхөөрөмжүүдийн их засварын 22 ажил графикийн дагуу бүрэн хийгдээд дууссан. Технологийн авто машины засварын 21 ажил 14 ажил бүрэн хийгдэж, хугацаа болоогүй 3 ажил, хийгдэж байгаа 3 ажил, дутуу хийгдсэн 1 ажил байна.
		Машин механизмуудад найдвартай ханган нийлүүлэгчээс чанарын шаардлага хангасан түлш шатахууныг авч ашиглах	“Шунхлай трейдинг” ХХК, “Содон Ойл” ХХК, “Багануур НИК” ХХК-ийн салбаруудаас, бензинийг “Сод Монгол” ХХК-аас гэрээ байгуулан авч ажиллаж байна. Өвлийн түлшний худалдан авалтын тендер зарласан одоогоор компани орж ирээгүй тул дахин зарлагдаад байна.
		Тэсэлгээний ажлыг стандартын дагуу өдрийн цагаар гүйцэтгэнэ.	Өрөмдлөгө тэсэлгээний ажил явуулах журам болон тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд нийцсэн тэсэлгээний ажлын паспорт боловсруулж, түүнийг мөрдөн өдрийн цагаар гүйцэтгэж ажилласан.
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Хуцаа голын гольдролд шүүрүүлэлтийн усыг тогтмол цутгах нөхөн сэргээх	Хуцаа голын гольдролыг 309.8 мян.м <sup>3</sup> усаар тэжээсэн.

	Хужиртын голын гольдролд шүүрүүлэлтийн усыг тогтмол цутгах, нөхөн сэргээх	Хужиртын голын гольдролыг 653.7 мян.м <sup>3</sup> усаар тэжээсэн.	
	Дулааны улиралд дотоод шүүрлийн усыг Уул-1 хэсгийн цөөрөмд цутгах	Дотоод шүүрлийн усыг цөөрөмд тогтмол цутгаж ажилласан.	
	Уурхайн шүүрүүлэлтийн усаар Багагүн нуурыг дулааны хугацаанд байнга сэлбэн тэжээх	Багагүн нуурыг 4-р сараас тэжээж эхэлсэн бөгөөд 35.6 мян.м <sup>3</sup> усаар тэжээсэн.	
	Багагүн нуурын хөлдөлтийн гүнийг давтан тодорхойлох	12-р сард хийгдэнэ.	
3	Хөрсөн бүрхэвч	Шинээр эвдрэлд орох талбайн үржил шимт хөрсийг хуулах, агуулахад байршуулах	Уул-1 хэсэгт 21.2 мян.м <sup>3</sup> , Уул-2 хэсэгт 56.9 мян.м <sup>3</sup> нийт 78.1 мян.м <sup>3</sup> шимт хөрсийг хуулж, 51.8 мян.м <sup>3</sup> хөрсийг ачиж агуулахад буулгасан.
	Шинээр үүссэн шимт хөрсний агуулахыг ургамалжуулах, элэгдлээс хамгаалах	Уул-2 хэсгийн 7-р сард хуулсан шимт хөрсийг мод үржүүлгийн газарт шууд буулгаж ашигласан. Уул-1 хэсгийн шимт хөрс хуулалтыг 8-10-р сард хийсэн тул ургамалжуулалтыг 2023 онд хийнэ.	
	Цэгүүдэд байрлуулсан бохир хөрсийг хөрс саармагжуулах талбайд цуглуулах, саармагжуулах	Бохир хөрсийг хөрс саармагжуулах талбайд 3 удаа цуглуулан саармагжуулсан.	
	2 дахь түүхий эдийн хөрсний бохирдлыг цэвэрлэх, саармагжуулах	2 дахь түүхий эдийн талбайн эхний суллагдсан хэсэг талбайг цэвэрлэсэн. 10-11-р сард үлдэгдэл тос маслыг өгөөд дахин цэвэрлэнэ.	
4	Газрын гадарга, хэвлий	Гравитацийн хүчний нөлөөллөөр явагдах геотехникийн процесст хяналт тавих	2023 оны байдлаар нийт 6 төрлийн хагарал Уул-2 хэсэгт үүссэн. Геотехникийн ажлын хүрээнд хэлтэс, хэсгүүдтай хамтран ажиллаж, аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг хүргүүлэн ажиллаж байна.
	Автозамын сүлжээг оновчтой маршрутаар тогтоож олон салаа зам үүсгэхгүй байхад хяналт тавьж ажиллах	Нүүрс гаргалтын ЭКГ-5А №1426 экскаваторын нүүрс тээврийн ТЭХ №1 хүртэлх 5.7 км замын талын зайг 3.6 км-ээр багасган ойртуулан ажилласан.	
5	Ургамлан нөмрөг	Нөхөн сэргээлт хийсэн талбайд ургамлан бүрхэцийг тодорхойлох, эрүүл талбайтай харьцуулах	Багануурын уурхайн ургамалжилтын төлөв байдлын судалгаагаар уурхайн орчимд нийт 28 овгийн 70 төрлийн 90 зүйл ургамал тэмдэглэгдлээ
6	Амьтны аймаг	Ан амьтны ажиглалт, тандалтыг хийх	Амьтны мониторинг судалгаагаар 6 зүйлийн хөхтөн амьтан, 78 зүйлийн шувуудыг бүртгэсэн.
	Шувууны суултуур хийж байрлуулах	6ш махчин шувууны суултуур хийж байрлуулсан	



## Гурав. НӨХӨН СЭРГЭЭЛТ

1. 2023 онд дотоод овоолгын нөхөн дүүргэлтийг Уул-1 хэсэгт 1797.8 мян.м<sup>3</sup>, Уул-2 хэсэгт 777.0 мян.м<sup>3</sup>, нийт 2,574.8 мян.м<sup>3</sup> хөрсөөр нөхөн дүүргэлт хийлээ.

2. Нөхөн сэргээлт, Тэрбум мод

Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах мод сөөгийг дотооддоо үржүүлэн бойжуулж нөхөн сэргээлтэд ашиглах, мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжиж хэрэгжүүлэх зорилгоор компаний мод үржүүлгийн газрыг шинээр байгуулан ажиллаж байна.

2022 онд 2ш, 2023 онд худалдан авсан 3ш нийт 5ш хүлэмж ашиглалтанд оруулахад бэлэн болгосон.





4 ш хүлэмжинд шинэс 80 000 ш, гүйлс 2000ш, голт бор 2000ш тарьсан.







Ил талбайн тарилтан үрээр болон мөчрөөр тарьж үржүүлэг хийсэн.  
1 га талбайд:








**Мод бутны суулгацын тоо**

Суулгацын төрөл	2022 онд	2023 онд	Нийт
Улиас	3,000	5,500	8,500
Хайлаас	180,000	80,000	260,000
Бургас	2,000	5,500	7,500
Шар хуайс	1,000	38,000	39,000
Шинэс		80,000	80,000
Гүйлс		2,000	2,000
Голт бор		2,000	2,000
Бүгд	186,000	213,000	399,000



### Цэцэгжүүлэлт, тохижилт

Гадна талбайн тохижилтонд 30 орчим төрлийн цэцгийн үрийг 3-р сард үрсэлгээнд тарьсан. Тусгайлсан палетанд үрээр тарьж соёолуулсаны дараагаар хайрцаганд сийрүүлж шилжүүлэлт хийн, байнгын усалж арчилан 6000 гаруй цэцгийн үрсэлгээг бэлтгэсэн. 6-р сарын эхээр компаний захиргааны байр орчмын болон бусад хэсэг нэгжүүдийн гаднах ил талбайд шилжүүлсэн. Нийт 2500м<sup>2</sup> талбайг цэцэгжүүлсэн.





## Мод бут арчилгаа, усалгаа

Хавар 3,4-р сард улиас модод хэлбэржүүлэх огтлолтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн дугуйн зам болон захиргааруу явсан төв автозам дагуу улиас модны нөхөн тарилт хийсэн. Мод бутны усалгаа арчилгааг тогтмол хийсэн.



## ”САЯ МОД”

**“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД ”БАГАНУУР” ХК НЭГДЭЖ 2030 ОН ХҮРТЭЛ 1 САЯ МОД ТАРИНА.**

Багануур ХК нь 960,000ш суулгацыг үржүүлэн 2026 оноос өөрсдийн суулгацыг хангахаар төлөвлөсөн хэдий ч 2023 оны тарих модыг өөрсдийн үржүүлсэн улиас, хайлаасны суулгацаас тарьж эхэлсэн.



2023 оны хаврын тарилт захиргаа орчим тарьсан.

д/д	Материалын нэр	Тоо ш
1	Тэхийн шээг	100
2	Хайлаас	200
3	Гүйлс	60
4	Монос	10
5	Өрөл	10
6	Шинэс	2
7	Даль	15
	Нийт	397





Бүх нийтийн мод тарих өдөр Багануур ХК-ийн ажилчид 3755 модыг тарив.



Намрын тарилтаар нийт 11240ш модыг өөрсдийн үржүүлсэн суулгацаар тарилтыг хийсэн.

д/д	Материалын нэр	Тоо ш
1	Улиас	1020
2	Хайлаас	10220

**“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны тоо**

Суулгацын төрөл	2022 онд	2023 онд	Нийт
Улиас	10,000	11637	21637

- ✚ Хөрөнгө оруулалтаар иж бүрэн агрегат бүхий пад тракторыг худалдан авч, мод үржүүлэг, тарилтын ажилд ашиглаж байна.
- ✚ Орон тооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үндсэн 3 ажилтан, гэрээт 12 ажилтанг нэмэгдүүлж ажилласан.
- ✚ Мод үржүүлгийн газрын агуулах, грашийн гадна үзэмжийг сайруулж, шинээр био 00 хийж байрлуулсан.
- ✚ Мод үржүүлгийн газрын цахилгааны монтажийг иж бүрэн шинэчилж янзалсан.
- ✚ Мод болон суулгац хадгалах зооринд гэрэлтүүлэг хийсэн.
- ✚ Шинээр мод усалгааны худгийг ашиглалтанд оруулсан.





**Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт**

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	
1.	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод нөхөн дүүргэлтийг алхагч экскаватороор буюу тээвэргүйгээр 2300.0 мян.м <sup>3</sup> хөрсөөр нөхөн дүүргэлт хийнэ.	Дотоод овоолгийн нөхөн дүүргэлтийг 2.6 сая.м <sup>3</sup> хөрсөөр нөхөн дүүргэлтийг хийсэн.
2.	Биологийн нөхөн сэргээлт	Мод үржүүлгийн газрын ил талбайд мод бутны үрсэлгээ хийх	1 га талбайд 133,000 модны үржүүлэг хийсэн.
		Хүлэмжинд шилмүүст модны үрсэлгээг хийх	4ш хүлэмжинд 80,000 ш шинэс модыг үрээр үржүүлсэн.
		Захиргаа орчмын мод бутны арчилгаа, усалгааг хийх, цэцэгжүүлэх, тохижилтын ажлыг хийх	Захиргаа орчмын моды бутны усалгаа, арчилгааг тогтмол хийж 6000 гаруй үрсэлгээг хийж 2500м <sup>2</sup> талбайг цэцэгжүүлсэн.
		Байгаль орчныг хамгаалах ажил болон нийгмийн хариуцлагын хүрээнд ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 10 000ш мод бут тарина.	Хаврын тарилтаар 397ш мод намрын тарилтаар 11240ш мод, нийт 8 төрлийн 11637ш модыг тарьсан. Бүх нийтийн мод тарих өдрөөр ажилчид 3755ш мод тарьсан.
		Мод үржүүлгийн газрын барилга байгууламжуудыг засаж янзлах	Агуулах, грашийн гаднах өнгө үзэмжийг засаж сайжруулан, зооринд гэрэлтүүлэг хийсэн.

## Дөрөв. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Аваргын голын урсац бүрэлдэх хөндлөн булгийн эхийг хашиж хамгаалахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу ажил хийгдэж эхэлж байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхэд залуучуудын спорт хөгжлийн талбайд 3200ш хайлаас модыг суулгасан.





**Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ		
		1	2	
1.	Аварга тосон ОНТХГН-ийг дүйцүүлэн хамгаалах	Дүйцүүлэн арга төлөвлөгөө, боловсруулах	хамгаалах хэмжээний төсөв	Орон нутгаас санал авч, төлөвлөсөн төсвийн дагуу ажил хийгдэж эхэлж байна.
		Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх	олон янз дүйцүүлэн арга батлагдсан дагуу	Аваргын голын урсац бүрэлдэх хөндлөн булгийн эхийг хашиж хамгаалах ажил хийгдэж байна.
2.	Гүн галуутай ОНТХГН-т дүйцүүлэн хамгаалах	Дүйцүүлэн арга төлөвлөгөө, боловсруулах	хамгаалах хэмжээний төсөв	Орон нутгаас санал авч, төсөвлөсөн төсвийн дагуу ажил хийгдсэн.
		Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх	олон янз дүйцүүлэн арга батлагдсан дагуу	

**Тав. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ**

Багануур ХК нь өөрийн эдэлбэр газарт үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд дүүргийн иргэд, оршин суугчид суурин учраас нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагагүй тул нөхөн олговор байхгүй.

**Зургаа. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ**


- 2013 онд Монгол улсын шинжлэх ухааны академи Палеонтологийн төвтэй гэрээ байгуулан уурхайн ашиглалтын талбайд судалгаа хийлгэсэн. Судалгаагаар цаашид үйл ажиллагаа явуулж байхад явуулж байх үед соёлын өв илэрсэн тохиолдолд ШУА-ийн Палеонтологийн төвд хандан хуулийн дагуу хамгаалах, малтлага хийлгэх ажил зохион байгуулах зөвлөмжийг өгсөн.
- Археологийн судалгааны ажлыг 2021 онд хийлгэсэн. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад газар дээр ил ямар нэгэн таних тэмдэггүй булц, хүний үйл ажиллагааны ул мөр, хөрс хуулалтын үед хүн малын яс, ваар сав, хүрэл, төмөр эдлэл болон бусад төрлийн эд өлгийн зүйлс илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэж зохих арга хэмжээг авахыг зөвлөсөн.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв		Зөвлөмж	
	1	2	3	
1.	Археологийн дурсгал	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад газар дээр ил ямар нэгэн таних тэмдэггүй булш, хүний үйл ажиллагааны ул мөр, хөрс хуулалтын үед хүн малын яс, ваар сав, хүрэл, төмөр эдлэл болон бусад төрлийн эд өлгийн зүйлс илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэж зохих арга хэмжээг авахыг зөвлөсөн		
2	Палеонтологийн дурсгал	Судалгаагаар цаашид үйл ажиллагаа явуулж байхад явуулж байх үед соёлын өв илэрсэн тохиолдолд ШУА-ийн Палеонтологийн төвд хандан хуулийн дагуу хамгаалах, малтлага хийлгэх ажил зохион байгуулах зөвлөмжийг өгсөн.		

### Долоо. Осол, эрсдэлийн менежмент

1. Болзошгүй аваарь ослын үед яаралтай хэрэглэх яаралтай тусламжийн эм тариа материал хэрэгсэл, ариутгал цэвэрлэгээ, хог хаягдал, анхан шатны бичиг баримтын стандартыг хангаж ажиллалаа. Сар бүр ХАБЭА-н нийт ажилтны сургалтаар анхны тусламжийн сургалтыг зохион байгуулж ажилласан.
2. Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн III шатны үзлэг хийх комисс нь компанийн хэсэг нэгжийн 2023 оны 1-3 дугаар улирлын ХАБЭА-н бичиг баримтууд, машин механизм, тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдхүүний техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, аюулгүй ажиллагаа, технологийн ажлын явц, паспортын мөрдөлт, ажлын байрны соёл, эрүүл ахуй, эрүүл мэнд, эмх цэгц, хүн нэг бүрийн ажлын, тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, түүний ашиглалтанд хяналт шалгалт хийсэн.

Болзошгүй осол, аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоног бүр 3-4 удаа ээлжит бус үзлэгийг тогтмол хийдэг бөгөөд нийт 128 удаагийн үзлэгийг хийж, 69 зөрчил илрүүлсний 100% буюу 65-ыг нь тухай бүрт нь, хөрөнгө, ажиллах хүч шаардсан 4 зөрчлийг хугацаатай үүрэг өгч арилгуулсан.





Илэрсэн зөрчлийн 48% буюу 33 нь цахилгааны аюулгүй байдлын, 40% буюу 27 нь технологийн, (зам, далан хамгаалалт г.м), 12% буюу 9 нь ажлын байр, орчны эмх цэгц, цэвэрлэгээтэй холбоотой зөрчил эзэлсэн.

Илэрсэн зөрчлийн 7 буюу 10%-ийг газар дээр нь шууд арилгуулсан бөгөөд 60 буюу 87%-ийг хугацаатай үүрэг өгч арилгуулсан, 2 буюу 3%-ийг хугацаа алдаж арилгасан байна.

“ХАБЭА-н сургалтын хөтөлбөр”-ийг 9 үндсэн, 32 дэд сэдвийн хүрээнд 12 цагийн багтаамжтай боловсруулан Үйлдвэрлэл, технологи эрхэлсэн дэд захирлаар батлуулан, Гүйцэтгэх захирлын А/109 тоот тушаалаар, батлагдсан хөтөлбөрийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн сар бүрийн 3 дахь долоо хоног бүр ХАБЭА-н сургалтыг танхимаар явуулахад сургалтанд нийт 981 ажилтан хамрагдахаас одоогийн байдлаар 697 ажилтан хамрагдаж, гүйцэтгэл 70,3%, мөн сургалтын үр дүнг үнэлэх шалгалтыг 981 ажилтнаас 156 ажилтан хамрагдсан.

3. ЭАШТ, ГЭД, АУД сургуулалт: Хэсэг, нэгжийн амилуулах суурь тусламж, гал эсэргүүцэх, аваар устгах дасгал сургуулийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг хянах, чиглүүлэх, хамрагдалтыг сайжруулах чиглэлээр хяналт тавьж ажилладаг бөгөөд эхний хагас жилийн байдлаар амилуулах суурь тусламж, гал эсэргүүцэх, аваар устгах дасгал сургуулийг нийт 25 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1563 ажилтныг хамруулсан, хамрагдалт 76%-тай, өмнөх оноос хамрагдалт 6%-иар өссөн.



4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран анх удаа зохион байгуулсан дадлага сургуульд Багануур ХК-ийн Гамшгаас хамгаалах штаб түүний дэргэдэх мэргэжлийн бүлгүүд, гамшиг тохиолдсон үед дайчлагдан ажиллах орчуулагчид, химийн бодистой харьцан ажиллах ажилтнууд, цусны донорууд, тоног төхөөрөмжүүдийг хариуцан ажиллах зэрэг нийт 150 гаруй ажилтан оролцлоо.

Багануур дүүргийн ослын удирдлагын төвтэй шууд холбогдон ажиллаж нийт 7 удаагийн цагийн байдалд шуурхай хариу арга хэмжээ авч, 10 төрлийн судалгаа гаргаж, дайчлагаанд оролцох 27 техник тоног төхөөрөмж, 150 гаруй

ажилтны биеийн байцаалт, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн ажиллалаа.



5. **А. Химийн бодисын зориулалт:** Засварын цехэд аккумуляторыг сэргээн засварлахад – хүхрийн хүчил / $H_2SO_4$ /, хүчилтөрөгчийн цехэд 25%-ийн аммиакийн уусмал / $NH_4OH$ /, аммонийн хлорид / $NH_4Cl$ /, засварын цехийн гагнуурчид – бура / $Na_2B_4O_7$ -г тус тус ашиглана.

**Б.Химийн бодисын төрөл:** Хүхрийн хүчил /sulphuric acid- $H_2SO_4$ /, 25%-ийн аммиакийн уусмал /ammonia- $NH_4OH$ /, аммонийн хлорид /ammonium muriate- $NH_4Cl$ /, бура /borax- $Na_2B_4O_7$ /

Химийн бодисын тооллогын хуудас

2023.10.20

<b>Аймаг, нийслэл</b>		Улаанбаатар хот	<b>Улсын бүртгэлийн дугаар</b>		9010001045
<b>Сум, дүүрэг</b>		Багануур дүүрэг	<b>Регистрийн дугаар</b>		2008572
<b>Аж ахуйн нэгжийн нэр</b>		Багануур ХК	<b>Үйл ажиллагааны чиглэл</b>		Нүүрс олборлох, борлуулах, боловсруулах
			<b>Зориулалтын агуулахтай эсэх</b>		Байгаа
№	Бодисын нэр	Химийн томъёо	Хэмжих нэгж	нийт хэмжээ	Хор, аюулын ангилал
1	Аммиак	$NH_4OH$	л	0,12	Онцгой цочроогч
2	Аммонийн хлорид	$NH_4Cl$	Кг	0.20	цочроогч
3	Натрийн борат	$Na_2B_4O_7 \cdot 10H_2O$	кг	6	
4	Хүхрийн хүчил	$H_2SO_4$	л	0,74	онцгой исэлдүүлэгч

Танхимын болон дадлага ажлын сургалтын хэлбэрээр Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын сайдын 2019 оны 12-р сарын 13-ний өдрийн А/370 тоот тушаалын дагуу ХАБЭА-н 1 жилийн эрх олгох сургалтанд химийн бодистой харьцан ажилладаг 20 ажилтанг хамруулж сертификат олгогдсон. /2023.04.17/



Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 03-р сарын 25-ны А/76 тоот тушаалын дагуу “Химийн бодисын аюул ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөө”-г 2023.10.09-ний өдөр батлуулсан.

6. Тэсрэх материалын агуулах нь байнгын байнгын 24 цагийн харуул хамгаалалттайгаар ажиллуулж байна.
7. Өрөмдлөгө тэсэлгээний ажил явуулах журам болон тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд нийцсэн тэсэлгээний ажлын паспорт боловсруулж, түүнийг мөрдөн ажилладаг.

**Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт
1		2	
1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед үүсэх гэнэтийн аюул осол	Болзошгүй аваарь ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах, анхан тусламжийн сургалтыг зохион байгуулах	Яаралтай тусламжийн эм тариа материал хэрэгсэл, ариутгал цэвэрлэгээ, материалыг хангаж, сар бүр ХАБЭА-н нийт ажилтны сургалтаар анхны тусламжийн сургалтыг зохион байгуулж ажилласан.
2	Хөдөлмөрийн аюулгүй бадйлыг хангах, эрүүл ахуйн бодлогыг хэрэгжүүлж ажиллах	ХАБЭА-н ээлжит болон ээлжит бус хяналтыг тогтмол хийх	7 хоног бүр 3-4 удаа ээлжит бус үзлэгийг тогтмол хийдэг бөгөөд нийт 128 удаагийн үзлэгийг хийж, 69 зөрчил илрүүлсний 100% буюу 65-ыг нь тухай бүрт нь, хөрөнгө, ажиллах хүч шаардсан 4 зөрчлийг хугацаатай үүрэг өгч арилгуулсан.
		ХАБЭА-н сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулах	2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн сар бүрийн 3 дахь долоо хоног бүр ХАБЭА-н сургалтыг танхимаар явуулахад сургалтанд нийт 981 ажилтан хамрагдахаас одоогийн байдлаар 697 ажилтан хамрагдсан.
		Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангах	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлийг тухай ханган ажиллаж байна.

3	Гал түймрийн аюул	Ажлын байруудад гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдалд хяналт тавих, хангамж бүрдлийг шалгах, Гал эсэргүүцэх дасгал сургуулилтыг зохион байгуулах	Гал эсэргүүцэх, аваарь устгах дасгал сургуулийг нийт 25 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1563 ажилтныг хамруулсан
4	Байгалийн гамшгаас үүдэлтэй аюул осол	Аваар устгах дасгал сургуулилтыг зохион байгуулах	Багануур дүүргийн ослын удирдлагын төвтэй шууд холбогдон ажиллаж нийт 7 удаагийн цагийн байдалд шуурхай хариу арга хэмжээ авч, 10 төрлийн судалгаа гаргаж, дайчлагаанд оролцох 27 техник тоног төхөөрөмж, 150 гаруй ажилтны биеийн байцаалт, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн ажиллалаа.
5	Химийн бодисын ашиглалтаас үүсэх эрсдэл	Химийн бодисын өрөөнд хадгалагдаж байгаа химийн бодисын тооллогын дүн мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлэх. Химийн бодис ашиглахтай холбогдуулан сургалт зохион байгуулах	Компанид хадгалагдаж байгаа химийн бодисын тайланг 1 болон 3-р улиралд багтаан тоолж холбогдох байгууллагуудад хүргүүлдэг. ХАБЭА-н 1 жилийн эрх олгох сургалтанд химийн бодистой харьцан ажилладаг 20 ажилтанг хамруулж сертификат олгогдсон. /2023.04.17/
6	Тэсэлгээ болон тэсрэх материалаас үүдэлтэй аюул осол	Тэсэлгээний материал хадгалдаг агуулахад байнгын 24 цагийн өндөржүүлсэн бэлэн байдлын харуултай байлгах. Тэсэлгээний ажлыг журмын дагуу тэсэлгээний ажлын паспорт боловсруулж, түүнийг мөрдөж ажиллах	Тэсрэх материалын агуулах нь байнгын байнгын 24 цагийн харуул хамгаалалттайгаар ажиллуулж байна. Өрөмдлөгө тэсэлгээний ажил явуулах журам болон тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд нийцсэн тэсэлгээний ажлын паспорт боловсруулж, түүнийг мөрдөн ажилладаг.



### Найм. Хог, хаягдлын менежмент

Хог хаягдлын менежментийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хог хаягдлыг ангилан ялгах, хаягдал хогнуудаас сэлбэгийн хогийг ялган ашиглах боломжтойг авч үлдэн, ашиглах боломжгүйг нь 2 дахь түүхий эдийн хашаанд хадгалж байна.
- Хадгалагдаж байгаа хог хаягдлаас дахин ашиглах боломжтойг журмыг дагуу шаардахаар авч ашиглаж байна. 2023 онд 29 нэр төрлийн 12432 нэгж хог хаягдлыг дахин ашигласан байна.

	Хэм/н	2020 он	2021 он	2022 он	2023 он
Дахин ашигласан хог хаягдал	Төрөл	33	37	35	29
	Нэгж	17299	32832	7853	12432

- Аюултай хог хаягдлыг 2 догч түүхий эдэд бүртгэлжүүлэн хадгалж байна.
- 2023 онд Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эрх бүхий “Эко стандарт петролиум” ХХК-тай гэрээ байгуулан 228тн ажилласан тос маслыг тушаасан. Тос маслыг бүрэн тушааж дуусаагүй байгаа тул хөрсийг хусаж цэвэрлэх ажил хойшлогдоод байна.



- Ахуйн хог хаягдлыг “Багануур тохижилт” ОНӨААТҮГ, Татварын албатай гэрээ байгуулан төвлөрсөн хогийн цэгт хаяж байна.
- Ахуйн хог хаягдлыг ангилж хаях ажлыг хэвшүүлж хэсэг тус бүрээс ангилан ялгаж хаясан дахиварыг авч хадгалж байна. 2023 онд хуванцар 133кг, Цаас 164.5кг, Кардонон цаас 13кг тус тус хэсгүүдээс хүлээж авсан байна.



- Долоо хоногийн 2 дахь өдөр цэвэрлэгээ хийхээс гадна улирал бүр их цэвэрлэгээг зохион байгуулж хийлгэж байна. Улирал бүр их цэвэрлэгээг зохион байгуулж хийлгэсэн.



- Жилд 1 удаа нэгдсэн байдлаар зохион байгуулагддаг компаний нийт ажилтнууд хамрагддаг ХАБЭА сургалтын хөтөлбөрт Хог хаягдлын сургалтыг оруулж сар бүрийн 3 дахь 7 хоногт хичээлийг өдөрт 2 удаагийн давтамжтайгаар зохион байгуулсан.
- Багануур дүүргийн бүх нийтийн их цэвэрлэгээгээр Нарийн нуур хэсгийн арын далангийн гадна талбайг цэвэрлэж даланд үүссэн хур хог хаягдлаас ачсан. Цэвэрлэгээнд хог хаягдлыг №137 ковш ачигчаар ачиж, камаз машинаар хогийн цэг рүү тээвэрлэсэн.







- Дүүргийн төвлөрсөн хур хогийн цэгийг дарж, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



ӨМНӨНЬ

ОДОО



## Ес. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

### Агаарын бохирдол

**NO<sub>2</sub>, SO<sub>2</sub>** - Агаар дахь бохирдуулагч бодис /азотын давхар исэл NO<sub>2</sub>, хүхрийн давхар исэл SO<sub>2</sub>-ын шинжилгээг улирал бүр хийлгэхээр БОХЗТЛ-той гэрээ байгуулан хийлгэж байна. 1,2,3-р улирлын шинжилгээг хийлгэсэн. 3-р улирлын шинжилгээний дүн гараагүй байна. 4-р улирлын шинжилгээ 11-р сард хийгдэнэ. Шинжилгээгээр агаарын бохирдлын хэмжээ стандартаас хэтрээгүй байна. /шинжилгээний дүнг хавсаргав/

**Тоосжилт:** Тоосжилтийн хэмжилтийг 6 цэгт 2 сар тутам Dust trak 85-20 загварын багаж ашиглан 24 цагийн турш хийж байна.

Тоосны хэмжилтийн дүн /2023 он/

Цэгийн агууламж	1-р сар	3-р сар	5-р сар	7-р сар	9-р сар	Стандарт мг/м3
Уул-1	0.133	0.015	0.052	0.003		0.1
Уул-2	0.371	0.021	0.013	0.004		0.1
Захиргаа	0.023	0.026	0.017	0.021		0.1
Дүүрэг /төв/	0.288	0.045	0.015	0.038		0.1
Дүүрэг /задгай/	0.592	0.113	0.036	0.02		0.1
Хяналтын цэг	0.131	0.039	0.029	0.015		0.1

Орчны тоосжилтийг агаарын чанарын индексээр үнэлэхэд: 1-р сард ихэнх хэсэгт стандарт түвшингээс хэтэрсэн АЧИ-ээр үнэлэхэд бага зэргийн бохирдолтой байна. Бусад цэгүүдэд стандарт түвшинд байна.

### Гадаргын ус

Гадаргын усны дээжийг 4 цэгээс авч 2-р улиралд БОХЗТЛ-д, 3-р улиралд Геологийн төв лабораторид тус тус шинжилгээ хийлгэсэн. /шинжилгээний дүнг хавсаргав/





Гадаргын усны ерөнхий үзүүлэлт

/2,3-р улирлын шинжилгээний дүнг стандарттай харьцуулав/

Шинжилгээ хийлгэх элемент			pH	SO4	Cl	ПИЧ	NH4	NO2	NO3	Рэрд	F
Стандарт	MNS 4586:98		6.5-8.5	100	300	10	0.5	0.02	9	0.1	1.5
Цэгийн байршил	Дээжний дугаар	Улирал	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л
Багагүн нуур зүүн	№11	2	7.77	3.6	9.9	15.4	0.32	0.005	0.11	0.027	0.92
		3	7.24	20.58	9.57	19.20	1.02	0.71	4.33		
Багагүн нуур баруун	№12	2	7.68	52.9	12.4	15.0	0.28	0.003	0.13	0.009	0.34
		3	7.34	13.17	6.03	17.92	1.40	0.02	2.47		
Хэрлэн гол дээд	№13	2	6.80	2.1	4.2	5.0	0.13	0.003	0.10	0.007	0.93
		3	7.48	2.47	2.84	6.88	0.16	<0.007	2.09		
Хэрлэн гол доод	№14	2	6.93	2.5	5.0	5.1	0.15	0.002	0.17		
		3	7.35	4.12	2.48	6.08	0.20	0.01	3.10		

Багагүн нуурын усны дээжийн ПИЧ нь стандарт хэмжээнээс өндөр гарсан байна. Багагүн нуурыг тэжээж байгаа коллекторын нуурт орж байгаа хэсэг буюу №8 нь стандарт хэмжээнд ПИЧ 2-4 байна.

Багагүн нуурын усны түвшин талбайн хэмжилт

Багагүн нуурын усны түвшин талбайн хэмжилтийг 2023.10.18-ны өдөр хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн дүнгээр 2022 оны 5-р сарын 12-ны өдрийн хэмжилтийг 2023 оны 10-18 ны өдрийн хэмжилттэй харьцуулахад талбайн хэмжээ 23,7 га-р нэмэгдэж 35,5 га болсон. Усны түвшин 1343.3 буюу 2022 оны түвшингээс 3.8 метр дээшилсэн байна. 2022 онд 1339.6 метр байсан. /маркшейдерийн хэмжилтийн зургийг хавсаргав/

Гүний ус:

Гүний усны шинжилгээг 1-р улиралд 6 цэгээс, 2,3-р улиралд 10 цэгээс дээж авч БОХЗТЛ болон Геологийн төв лабораториор шинжилгээг хийлгэсэн. /шинжилгээний дүнг хавсаргав/

Гүний усны ерөнхий үзүүлэлт.

/1,2,3-р улирлын шинжилгээний дүнг стандарттай харьцуулав/

Шинжилгээ хийлгэх элемент			pH	Эрд	Ж/б	ПИЧ	NH4	NO2	NO3	P
							Нийт азот			
Стандарт	MNS 4943:2015		6.-9	1000	30	20	15			1.5
Цэгийн байршил	Дээжний дугаар	Улирал	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мгN/л	мг/л	мгP/л
УШХ ус хураагуур	№1	1	7.63	861	2.2	1.2	0.53	0.085	0.80	0.005
		2	7.61	648	81.6	1.3	0.28	0.056	0.15	
		3	7.73	820		5.04	0.05	<0.007	<0.1	
		4								
Төмөргүйжүүлэх станц	№2	1	7.86	856	1.6	1.3	0.26	0.049	1.59	0.003
		2	7.64	650	3.2	1.4	0.004	0.011	0.34	
		3	7.69	800		2.72	<0.05	<0.007	1.52	
		4								
ЦБ-тай нийлэхээс өмнө	№3	1	8.06	823	31.2	3.2	0.13	0.082	1.55	
		2	7.76		42.4	6.1	0.04	0.019	0.36	0.006

		3	7.83	790		1.52	<0.05	<0.007	2.37	
		4								
ЦБ-тай нийлсний дараах	№4	1			10.8	11.4	32.8	1.353	28.7	
		2	7.78		53.0	12.3	6.80	0.259	5.14	1.392
		3	7.41	737		3.12	<0.05	0602	34.54	
		4								
Хужиртын голын голдиролд цутгаж байгаа коллектор	№5	1	7.43	1392	3.6	0.9	0.89	0.038	0.58	0.004
		2	7.42	1050	2.4	0.8	0.64	0.006	0.11	
		3	7.70	780		8.16	<0.05	<0.007	3.98	
		4								
Хуцаагийн голын голдиролд цутгаж байгаа коллектор	№6	1	7.86	816	6.2	0.6	0.45	0.059	0.008	0.003
		2	7.51	589	2.0	1.0	0.23	0.008	0.02	
		3	7.23	1333		4.88	0.56	<0.007	2.21	
		4								
Багагүн нуур тэжээх дээд коллектор	№7		Коллектор 5 сараас ажиллаж эхэлдэг							
		2	7.78	671	3.0	9.0	0.52	0.003	0.01	
		3	7.20	878		16.72	0.48	<0.007	3.48	
		4								
Багагүн нуур тэжээх доод коллектор	№8		Коллектор 5 сараас ажиллаж эхэлдэг							
		2	7.99	582	2.6	2.5	0.04	0.001	0.05	
		3	8.89	586		4.48	0.15	0.03	0.63	
		4								
Нарийны гол /Хэрлэн голд цутгахын өмнө/	№9	2	8.09	586	3.2	5.6	4.28	0.352	4.28	
		3	7.61	158		5.52	<0.05	<0.007	0.82	
Аягын гол /Хэрлэн голд цутгахын өмнө/	№10	2	8.35	992	22.2	8.4	0.35	0.0007	0.16	
		3	6.92	1810		21.92	1.23	<0.007	4.65	

- №3 буюу дулааны станцаас гараад цэвэрлэх байгууламжтай нийлэхийн өмнөх усны 1,2-р улирлын усны дээжийн ЖБ-ын агууламж стандартаас хэтэрсэн. №2 буюу төмөргүйжүүлэх, дулааны станц руу орохоос өмнөх ус стандарт хэмжээнд байгаа нь Дулааны станцаар ороод гарахдаа бохирдолд өртсөн байна.
- Цэвэрлэх байгууламжийн устай нийлсэнийх дараах буюу №4-ын 3-р улирлын усны дээжийн нийт азот болон 1-р улирлын усны дээжийн ЖБ-ын агууламж стандартаас тус тус хэтэрсэн байна.
- №5-ын 1,2-р, №6-ын 3-р улирлын улирлын усны дээжийн эрдэсжилтийн агууламж стандартаас бага зэрэг хэтэрсэн.
- №10-ын 3-р улирлын усны дээжийн эрдэсжилт болон ПИЧ-ын агууламж стандартаас хэтэрч нэмэгдсэн нь замдаа бохирдолд өртсөн байна.

#### Гүний усан дахь хүнд металлын агууламж

- Гүний усанд дахь хүнд металлын элементүүд нь стандартаас хэтэрсэн тохиолдол байхгүй байна. /Шинжилгээний дүнг хавсаргав/
- Гүний усны түвшиний хэмжилтийг сар бүр хэмжин хянаж байна.



**Хөрс**

- Хөрсний агрохимийн үзүүлэлтийг дулааны улиралд 1 удаа 13 цэгээс дээж авч БОХЗТЛ-иор шинжилгээг хийлгэсэн. /Шинжилгээний дүнг хавсаргав/
- Шинжилгээгээр уурхайн шимт хөрсний агуулахад хадгалагдаж байгаа шимт хөрсний ялзмагийн агууламж 2,13-9,23-ын хооронд байна.
- Хөрсний хүнд металлын үзүүлэлтийг мөн дулааны улиралд 1 удаа 8 цэгээс дээж авч БОХЗТЛ-иор шинжилгээг хийлгэсэн. Шинжилгээний дүнг стандарттай харьцуулахад хэвийн хэтрээгүй байна. /Шинжилгээний дүнг хавсаргав/
- Хөрсөн дэхь нефьтын агууламжийг 3, 8-р саруудад 2 удаа дээж авч шинжилгээг БОХЗТЛ-иор хийлгэсэн.

**Цацраг**

Цацрагийн хяналтын хэмжилтийг 10-р сард БОХЗТЛ-иор хийж гүйцэтгэсэн.. Гадаад орчны гамма цацрагийн тунгийн чадал уурхайн нүүрсний мөргөцгүүдэд цагт 0,09-0,20 мкЗв байгаа нь байгалийн цацрагийн ердийн түвшинд байна.



**2023 оны цацраг тунгийн чадлын хэмжилтийн дүн**

Цэгийн дугаар	Цэгийн байршил	Цацраг тунгийн чадал /мкЗв/цаг/	
		Агаар	Хөрс
1	Уурхайн захиргаа	0.10	0.12
2	Нөхөн сэргээсэн талбай	0.10	0.12
3	ЭКГ№1426 мөргөцөг/гаргалт/	0.11	0.11
4	2111 гидро экскаватор /гаргалт/	0.15	0.20
5	114 гидро экскаватор /гаргалт/	0.14	0.16
6	ЭКГ№1592 мөргөцөг	0.12	0.13
7	ЭКГ №15/81 мөргөцөг	0.11	0.11
8	ЭШ 10/70 №61 мөргөцөг	0.12	0.12
9	Дулааны станц орчим	0.10	0.12
10	Үнсэн сан	0.10	0.11
11	Дүүрэг төв	0.10	0.10
12	Гэр хороолол	0.11	0.12
13	Эрүүл газар	0.09	0.09

## Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Цэгийн тоо	Хугацаа ба давтамж	Нийт хэмжилтийн тоо
1	Агаар - Бохирдол - Тоосжилт	6	Улирал бүр 2 сар тутам	18 30
2	Гадаргын ус - Хими - Хүнд металл	4	Дулааны улиралд	8
3	Багагүн нуур - Түвшин - Талбай	1	3 удаа	2
4	Гүний ус - Хими - Хүнд металл	6,10	Улирал бүр	26
5	Гүний ус - Түвшин	Гүний усны ажиглалтын цооногуудад	Сар бүр	10 удаа
6	Хөрс - Агрохимийн үзүүлэлтүүд	12	Дулааны улиралд	13
7	- Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд	7	Дулааны улиралд	8
8	- Хөрсөн дэх нефьтийн агууламж	3	3-9-р сар	8
9	Цацраг	10	Жилдээ	13



**Арав. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах батлуулах, биелэлтийн тайланг гаргаж тайлагнах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Биелэлтийн тайланг хагас жилээр гаргаж холбогдох газруудад тайлагнасан.
2	Байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ байгуулж шинжлүүлэх, хяналт тавьж ажиллах	БОХЗТЛ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн усны шинжилгээг Геологийн төв лабораториор ээлжилж хийлгэсэн.
4	Байгаль орчны аудитын ажлыг хийлгэх	Зөвлөх үйлчилгээний тендер зарлаж хураангуй жагсаалт үүссэн. 11-р сард гэрээ байгуулна.
5	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийлгэх	Зөвлөх үйлчилгээний тендер 2 удаа зарлагдан амжилтгүй болсон. Дахин зарлагдаад байна.
6	Байгаль орчноо хайрлан хамгаалах, зүй зохистой ашиглах талаарх сургалт хийх	ХАБЭА-н сар бүрийн сургалттай хамтатган Байгаль орчин, мод бут тарих талаарх 1 цагийн сургалтыг орсон.
7	Мод бут тарих, арчлах арга аргачиллын талаар сургалт, практик хийх	Мөн 1-р сард “Хариуцлагатай уул уурхай, нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээ” 19 цагийн сургалтанд 3 ажилтнаа хамруулсан. Багануур дүүргийн “Боловсрол цогцолбор” ЕБС-ийн 6-12-р ангийн нийт 43 ангийн 1100 гаруй сурагчдад Байгаль орчин, мод тарих арга, хог хаягдлын талаар сургалтыг хийсэн.

**Арван нэг. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Биелэлт
1		2	5
1	БОАЖЯамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн газар	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу БОМ-ийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг 3% хэвлэмэл болон цахим хэлбэрээр албан бичгээр хүргүүлэх	12-р сард
2	Нийслэлийн БОГазарт	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу	2023 оны БОМТ-ийн биелэлтийн тайланг цахимаар оруулж байна.
3	Багануур дүүргийн ЗДТГ “Эрдэнэс МГЛ” ХХК	БОМ-ийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр албан бичгээр хүргүүлэх	Хагас жилээр 7-р сард хүргүүлсэн.
5	Дүүргийн оршин суугч, иргэд, байгууллага	Иргэд, ААНБ-уудыг уурхайтай танилцуулах, хорооны оршин суугч, иргэдийн төлөөллийг уурхайн байгаль орчин, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай танилцуулах, илтгэл тавих	Уурхайтай танилцахаар ирсэн иргэд, аж ахуйн нэгж байгууллагад танилцуулах ажлыг тухай бүр зохион байгуулж хийсэн. Хорооны иргэдэд танилцуулах ажлыг 9-р сард хийсэн.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Багануурын уурхайн байгаль орчин, нөхөн сэргээлт болон Тэрбум үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа Мод үржүүлгийн газрын үйл ажиллагаатай танилцуулах ажлыг 9-р сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Тус өдөрлөгт Багануур дүүргийн 5 хорооноос иргэдийн төлөөлөл болох 36 иргэн хүрэлцэн ирсэн.

